

Хатгал тосгоны төв доторх ухаалаг цахим худгийн ажлын техникийн тодорхойлолт

2024-10-22

Хатгал тосгон

Хатгал тосгоны төв хэсэгт ундны усны зориулалттай смарт /цахим/ гүний худгийн байрыг тохижуулан ашиглалтанд оруулах ажлын даалгавар.

Ухаалаг худгийн ажлын даалгавар:

- Усны сав байрлуулах: 1,5тн 1ш, 2,5тн 2ш нержэн, зэвэрдэггүй материалаар хийгдсэн, тагтай, хүний биед сөрөг нөлөөгүй, эрүүл мэндийн шаардлага хангасан 3ш сав байрлуулах.
- Цахилгаан халаагуур: /ухаалаг тенн/ 16м² байрыг халаах хүчин чадалтай байх.
- Гадна талбайн ус авдаг хэсгийг цементлэсэн байх, усны машины ус ачих талбайг цементлэж бэлдэх.
- Ундны ус авах хоолой: хоолой нь зэс голтой байх ба цонхны дор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/ .
- Усны машинд ус олгох ухаалаг /карт/ төхөөрөмж суулгах.
- Усны машинд ус ачих өндөр хоолой гаргаж өгөх. Өвөл хөлдөөхгүйн тулд халдаг зориулалтын утас холбож өгөх.
- Камер суурилуулах / гадна, дотор /, дэлгэц, модемийг байранд тоноглолын хамт байрлуулах.
- Хэрэглэгчдийн хэрэглэх картыг /100ш/ захиалагчид хүлээлгэн өгөх.
- Ус түгээх байрны гадна талбайг гэрэлтүүлэх гэрэлтүүлэг хийх.
- Цахилгааны эх үүсвэрийг 380квт-ын цахилгаан татаж, худгын байранд оруулах.
- Тог тасарсан үед хэрэглэх цахилгаан генератортой байх / 380 гаргадаг бензинээр ажилладаг байх /
- Цахилгааны монтажийг мэргэжлийн хүмүүсээр хийлгэсэн байх баталгаажуулсан тоолуур тавьсан байх. Сайн чанарын кабел утас ашиглах. Аюулгүй байдал, галын аюулаас сэргийлсэн байх.
- Усны гарцыг шалгуулж ажлын хэсэгт хянуулна, дүгнэлт гаргуулах.

- Барилга захиалагчийн хяналтын зардлын 1,6%-ийг тендерийн үнэнээс хасч шилжүүлнэ.
- Хамгаалалтын хашаа хийсэн байх / мал , амьтан орхооргүй /.
- Худгын байранд ашиглах заавар буюу самбар байрлуулж өгөх.
- Замын хажууд худаг гэсэн тэмдэглэгээ хийх.
- Худгийн байранд сандал, ширээ байрлуулах.
- Нийт төсөвт өртөг 55,000,000 төгрөг.

Хянасан: ЗАА-ны даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Боловсруулсан: ЗАА-ны нягтлан бодогч



Ч.Батбаяр

П.Бямбаням